

ҮЗЗ-ийн уулзалтын тэмдэглэл

Уулзалтын талаар							
ГС-ийн ҮЗЗ		Монгол Улс			Хуралд санал өгөх эрхтэй гишүүдийн тоо		12
Уулзалтын №		84					
Огноо		2020 оны 05 сарын 11			ҮЗЗ-ийн гишүүн бус оролцогчдын тоо, уригдаж ирсэн зочид		5
ХУРЛЫН ДАРГА							
Нэр/ Байгууллага	Овог	Ц			Хурлын зорилгод хүрсэн эсэх (тийм, үгүй)		ТИЙМ
	Нэр	Адъяахишиг			Хурлын үргэлжилсэн хугацаа (цагаар)		2.40
	Байгууллага	ХЭҮК-ын Ахлах референт			Хурал зохион байгуулагдсан газар	Zoom application	
ҮЗЗ-д гүйцэтгэх үүрэг (Тохирох нүдийг бөглөнө үү)	Дарга			Уулзалтын төрөл (Тохирох нүдийг бөглөнө үү)		Ээлжит	X
	Дэд дарга					Ээлжит бус	
	Гишүүн			x		Хорооны уулзалт	
	Гишүүнийг орлогч					Бусад байгууллагын оролцоо (Тохирох нүдийг бөглөнө үү)	СОНА
Салбар * (Тохирох нүдийг бөглөнө үү)							
ЗГ	ОУБ	ТББ	Боловсрол	Өвчлөлт бүлгийн хүн ам	Эрсдэлт бүлгийн хүн ам	Шашны Байгууллага	Хувийн Хэвшил
x							
						FRM / PO	
						бусад	X
						оролцоогүй	

ХӨТӨЛБӨР ТУС БҮРТ ХАМААРАХ СЭДВИЙГ СОНГОНО УУ (Тохирох нүдийг бөглөнө үү)													
ҮЗЗ-ийн ЗАСАГЛАЛ, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮДТЭЙ ХОЛБООТОЙ СЭДВҮҮД													
Ажлын явц	ҮЗЗ-ийн жилийн ажлын төлөвлөгөө болон төсвийг хянах	АСЗ	ҮЗЗ-ийн гишүүнчлэлийн асуудал	Тогтвортой байдал	ҮЗЗ болон хамтрагч байгууллагуудын уялдаа холбоо	Хүйсийн эрх тэгш байдал	Төсөл боловсруулах	УХА, СХА	Тэтгэлэг	Хяналт (удирдлага, СОНА аудит)	Санхүүжилтийг үргэлжлүүлэн олгох талаар / төслийн II үе/, хаалт	Техникийн туслалцаа авах шалгаруулалт	Бусад
Хөтөлбөр													
№.	Хөтөлбөрийг дурдана уу												
Хөтөлбөр #1	Хурлын нээлт, хурлаар хэлэлцүүлэх асуудлууд, өмнөх хурлын шийдвэрийн биелэлтийг танилцуулах												
Хөтөлбөр #2	Глобаль сангийн дэмжлэгтэй ХДХВ/ДОХ-ын төслүүдийн хэмнэгдсэн санхүүжилтийг COVID-19 цартахалтай тэмцэх чиглэлд дахин хуваарилах тухай												
	x												
	x												

Хөтөлбөр	
№.	Хөтөлбөрийг дурдана уу
Хөтөлбөр #1	Хурлын нээлт, хурлаар хэлэлцүүлэх асуудлууд, өмнөх хурлын шийдвэрийн биелэлтийг танилцуулах
Хөтөлбөр #2	Глобаль сангийн дэмжлэгтэй ХДХВ/ДОХ-ын төслүүдийн хэмнэгдсэн санхүүжилтийг COVID-19 цартахалтай тэмцэх чиглэлд дахин хуваарилах тухай

Хөтөлбөр #3	2018-2020 онд хэрэгжиж буй ХДХВ/ДОХ, Сүрьеэгийн төслүүдийн хэмнэгдсэн санхүүжилтийг дахин хуваарилах тухай	x																	
Хөтөлбөр #4	Зохион байгуулалтын асуудал: <ul style="list-style-type: none"> • ҮЗЗ-ийн даргын хугацааг хэлэлцэх • Хяналтын хорооны зарим гишүүдийг чөлөөлж, нөхөн сонгох 				x														

Хөтөлбөр тус бүрээр хийсэн тэмдэглэл			
Хөтөлбөр #1	Хурлын нээлт, хурлаар хэлэлцүүлэх асуудлууд, өмнөх хурлын шийдвэрийн биелэлтийг танилцуулах.		
Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.			
Байхгүй.			
Ямар нэгэн маргаан гарсан эсэх(гийм эсвэл үгүй)>			Үгүй
Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй			
1. В.Мягмар: CCM Chair В.Мягмар chaired the meeting, introduced the agenda to the members and approved the agenda. Due to personal reasons given to В.Мягмар, the meeting was left to be chaired by Ts.Adiyakhishig, Senior Officer of the NHRCM.			
Өмнөх 82, 83 дахь ҮЗЗ-ийн хурлын шийдвэрийн үйл явцын талаар ҮЗЗ-ийн зохицуулагч Б.Оюундарь гишүүдэд танилцуулав.			
ҮЗЗ 82 ДАХЬ ХУРАЛ 2019 ОНЫ 11 САРЫН 21-НД БОЛСОН			
ХӨТӨЛБӨР		ХАРИУЦАЖ БУЙ ХҮН	ГҮЙЦЭТГЭЛ
Хөтөлбөр-1	Хурлын нээлт, хурлаар хэлэлцүүлэх асуудлууд, өмнөх хурлын шийдвэрийн биелэлтийг танилцуулах	ҮЗЗ-ийн ажлын алба	100%
Хөтөлбөр-2	ХДХВ/ДОХ, сүрьеэгийн төслүүдийн үйл ажиллагааны биелэлтийг танилцуулах (Хяналтын хорооноос гарсан шийдвэрийн дагуу) <ul style="list-style-type: none"> • Төслийн шугамаар бэлтгэгдсэн эмч нарын мэдээлэл; • Жене-экспертийн ашиглалтын байдал; • Эмчилгээ алдагдалт, лабораторийн чанар 	ЭМЯ-ны НЭМГ	
Хөтөлбөр-3	Булган, Хөвсгөл аймгуудад хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцах ажлаас гарсан зөвлөмжийг танилцуулж батлах	ҮЗЗ-ийн ажлын алба	100%
Хөтөлбөр-4	Глобаль сангийн дэмжлэгтэй ХДХВ/ДОХ, Сүрьеэгийн төслүүдэд хөндлөнгийн үнэлгээ хийсэн тухай тайланг танилцуулах	Зөвлөхүүд	50% Сүрьеэгийн тайлан ГС-с ирсэн
Хөтөлбөр-5	Глобаль сангийн үйл ажиллагатай холбоотой Эрүүл мэндийн сайдын А/460, А/511 тоот тушаалуудын хэрэгжилтийг танилцуулах; 2021-2023 онуудад хэрэгжүүлэх Глобаль сангийн төсөл боловсруулах ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах	ЭМЯ	А / 460-100% А / 511-60% (Transition and Stability Plan Development)
Хөтөлбөр-6	Уул уурхай, зам тээврийн салбар дахь ХДХВ/ДОХ, Сүрьеэ өвчинтэй тэмцэхэд хамтын ажиллагааг бэхжүүлэх нь" зөвлөлдөх уулзалтын талаар ҮЗЗ-ийн гишүүдэд танилцуулан, санал авах	ҮЗЗ-ийн ажлын алба	80% Ажлын хэсэг байгуулагдсан

Хөтөлбөр-7	Зохион байгуулалтын асуудал: <ul style="list-style-type: none"> • ҮЗЗ-ийн даргын хугацааг хэлэлцэх • Хяналтын хорооны зарим гишүүдийг чөлөөлж, нөхөн сонгох 	ҮЗЗ-ийн гишүүд	-
------------	---	----------------	---

ҮЗЗ 83 ДАХЬ ХУРАЛ 2020 ОНЫ 04 САРЫН 23-НД БОЛСОН

ХӨТӨЛБӨР		ХАРИУЦАЖ ХҮН	БУЙ	ГҮЙЦЭТГЭЛ
Хөтөлбөр-1	Төслийн санхүүжилтийн дахин төлөвлөлтийн тухай	ҮЗЗ-ийн алба	ажлын	100%

Хөтөлбөр #2	Глобаль сангийн дэмжлэгтэй ХДХВ/ДОХ-ын төслүүдийн хэмнэгдсэн санхүүжилтийг COVID-19 цартахалтай тэмцэх чиглэлд дахин хуваарилах тухай
--------------------	--

Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.

Байхгүй

Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тийм эсвэл үгүй)

Үгүй

Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй

Глобаль сангийн дэмжлэгтэй ХДХВ/ДОХ-ын төслүүдийн хэмнэгдсэн санхүүжилтийг COVID-19 цартахалтай тэмцэх чиглэлд дахин хуваарилах тухай

Ж.Лхамсүрэн-ХЗН-ийн мэргэжилтэн танилцуулгыг танилцууллаа. /Хавсралт №1/

Танилцуулгын товч хураангуй

Төсвийг бүхэлд нь авч үзвэл :

	Сүрьеэгийн төсөл-\$	ХДХВ/ДОХ төсөл-\$	COVID-19 хариу арга хэмжээнд
Нийт батлагдсан санхүүжилт	8,919,718	2,925,360	
Батлагдсан санхүүжилтийн 5%	445,986	146,268	
Ханшийн зөрүүнээс үүссэн хэмнэлт: (171,560\$)	99,160	72,400	83 дахь ҮЗЗ-н хурлаар баталсан: <ol style="list-style-type: none"> 1. 11 ш амьсгалын аппарат-423,500,000₮ 2. Халдваргүйжүүлэх бодис-53,640,000₮
2018-2019 оны гүйцэтгэлээс хэмнэгдсэн хэмнэлт:	350,000	73,868	84 дэх ҮЗЗ-н хурлаар хэлэлцэх: <ol style="list-style-type: none"> 1. Сүрьег оношлох Gene Expert-н 1 жилийн хэрэглээний 12,672ш оношлуур-145,437\$ 2. 104,687 ширхэг N95 амны хаалт -66,128\$ 3. Сүрьеэгийн өвчлөл өндөр 9 аймагт сүрьеэгийн амьсгалын аппарат-138,435\$
2020 онд Сүрьеэгийн 2-р эгнээний эмийн худалдан авалтаас хэмнэгдсэн хэмнэлт:	350,000	-	84 дэх ҮЗЗ-н хурлаар хэлэлцэх: <ol style="list-style-type: none"> 1. COVID-19-г оношлох оношлуур-14,730ш 291,654\$ 2. Тээврийн зардал 20%-58,346\$

Глобаль сангаас 2020 онд сүрьеэгийн 2-р эгнээний эмийн худалдан авалтанд нэмэлтээр батлагдсан санхүүжилтийг дахин төлөвлөн зарцуулах тооцоо

№	Худалдан авах бараа	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Serheid компаний үйлдвэрлэсэн Gene Expert аппаратанд ашиглах Expert Xpress SARS-CoV-2 оношлуур	14,730	\$ 19.80	\$ 291,654.00
2	Тээврийн зардал 20%			\$ 58,345.80
Нийт үнэ				\$ 350,000

Хэлэлцсэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга

УАБЗ	<p>Ж.Мөнхжаргал: Хасах асуудал-Хэлэлцэх асуудлаас Дүрмийн өөрчлөлтийг хэлэлцэх гэсэн асуудлыг хасах. ҮЗЗ-ийн дүрмийг өөрчлөх шаардлагагүй учир хэлэлцэх шаардлаггүй.</p> <p>Нэмэх асуудал-Төсвийг өөр ямар үйл ажиллагаанд зарцуулах тухай асуудлыг гишүүдээс дэвшүүлэх</p>
ТББ	<p>Г.Нямпүрэв: ЭМЯ болон ЗГ-с COVID-19-тэй холбоотой санхүүжилт гаргаж байгаа тиймээс заавал ҮЗЗ-ийн ХДХВ/ Сүрьеэгийн төслөөс мөнгө дахин төлөвлөх шаардлага байгаа юу? ЗГ-с COVID-19-тэй холбоотой хэдэн төгрөг юу юунд зарцуулахаар уг мөнгийг авч байгаа вэ?</p>
Хариулт	<p>Ж.Лхамсүрэн: ЗГ-с COVID-19-тэй холбоотой хэдэн төгрөг зориулж байгааг бол гаргах боломжгүй гэвч COVID-19-тэй холбоотой хэрэгцээ шаардлага юу байгаа эсэх дээр судалгаа хийсэн. Үүнд: 450 ор бэлэн байлгах, амьсгалын аппарат 376 ш шаардлагатай байгаагаас 304 ш аппарат дутагдалтай байгаа, үүнээс 11 ш аппаратыг ГС-с санхүүжүүлэх хүсэлтийг ЭМЯ-с ирүүлсэн (171,560\$). 350,000\$ -с 9 ш амьсгалын аппаратыг өвчлөл өндөр байгаа аймгуудын халдварт сүрьеэгийн тасагт өгөх юм.</p>
ТББ	<p>Ч.Сэмжидмаа: Вальютин ханшийн зөрүүгээс үүссэн 171,560\$ талаар яриад байна гэсэн чинь ахиад 350,000\$ асуудал гарч ирсэн нь ГС-ийн 5%-ийн санхүүжилт юм уу? Нийт хэдий хэмжээний хэмнэлт яригдаж байна вэ?</p>
Хариулт	<p>Ж.Лхамсүрэн:</p> <ol style="list-style-type: none"> Ханшийн зөрүүнээс үүссэн хэмнэлт болох 171,560\$ байгаа ба ЭМЯ-с үүгээр 11 ш амьсгалын аппарат, халдваргүйжүүлэх бодис авах хүсэлт ирүүлсэн. Үүнийг өмнөх 83 дахь удаагийн хурлаар ҮЗЗ гишүүд баталсан. Одоо ахин 350`000\$, 350`000\$-ийн 2 хэмнэлт бий болсон. Эхнийх нь 2018-2019 оны гүйцэтгэлээр ханган нийлүүлэгдсэн барааны нэгж үнийн зөрүү болон ачилт тээврийн зардлаас хэмнэгдсэн. Үүгээр ЭМЯ-с 12 ш Жене Эксперт аппаратны 1 жилийн хэрэглээний оношлуур авах, N95 маск, Сүрьеэгийн өвчлөл өндөр 9 аймагт сүрьеэгийн амьсгалын аппарат авах хүсэлт ирүүлсэн. Дараагийнх нь 2020 онд олон эмэнд дасалтай сүрьеэгийн эмийн ханган нийлүүлтэнд зориулж нэмэлтээр 350,000\$ баталж өгсөнийг 2019 онд эмчилгээнд орсон хүний тоо төлөвлөсөн тооноос даруй 100 хүнээр бага байсантай холбоотой мөн ДЭМБ-ын олон эмэнд дасалтай сүрьеэгийн эмнэлзүйн заавар шинэчлэгдсэнтэй холбоотойгоор эмчилгээний горим өөрчлөгдөж эмийн нөөц хангалттай байгаа тул уг мөнгө зарцуулагдахгүй болсон. Үүгээр ЭМЯ-с Expert Xpress SARS-CoV-2 оношлуур болон түүний тээвэрлэлтэнд зарцуулах хүсэлт ирүүлсэн.
ДЭМБ	<p>Др.Сергей:</p> <ol style="list-style-type: none"> Нэмэлтээр 12 ш Gene Expert аппарат захиалсан гэж байна. Миний мэдэж байгаагаар 17 аймаг, зарим дүүргүүдэд уг аппарат байхгүй байгаа, хэрвээ дээрх 12 ш аппарат ирвэл бүх аймаг, дүүргүүд бүрэн хангагдах уу, энэ талаар мэдээлэл өгнө үү. COVID-19-тэй холбоотой дахин төлөвлөлтийг бүрэн дэмжиж байгаа ялангуяа түргэвчилсэн оношлуурыг авах саналыг, хэрвээ улс орон дотор дэгдэлт гарсан тохиолдолд бүх аймаг, дүүргүүд түргэн хугацаанд оношлох боломжтой болж лабораторын чадавхийг дээшлүүлэх юм. ДЭМБ, ГС, UNICEF хоорондоо COVID-19-тэй холбоотой аль шаардлагатай байгаа ханган нийлүүлэлтээ хувааж авсан байгаа ба ГС Gene Expert-ийн оношлуурыг хариуцаж байгаад баяртай байна. ЗГ-с 15,000 ш оношлуур авах шаардлагатай байгаа гэж байгаа боловч дэлхий даяар эрэлт маш их байгаа. Бидний авсан мэдээллээр МУ оношлуураар хангаж болох улсуудын эхний эгнээнд байгаа боловч одоогоор хангах боломжтой байгаа нь 2000 ш гэсэн байсан, тиймээс энэ талаар ГС-ийн хүмүүстэйгээ хэдий хэмжээний оношлуур захиалах боломж байгаа талаар сайн тодруулаарай. ДЭМБ нь НҮБ-с COVID-19-тэй холбоотой том төсөл аваад хэрэгжүүлэх гэж байгаа энэ төсөлд бас оношлуурыг тусгасан байгаа, цаашид хамтраад ажиллаж болох байх.

Хариулт	<p>Ж.Лхамсүрэн:</p> <p>1. 2019 оны байдлаар 20 ш Gene Expert аппараттай байгаа ба энэ ДЭМБ болон ГС-ийн санхүүжилтээр авсан. 2020 онд 12 ш аппарат нэмж авсанаар нийт 32 ш Gene Expert аппараттай болох юм. Ингэснээр бүх 21 аймаг, 9 дүүрэг болон зарим сум дундын эмнэлэгүүд уг аппаратаар бүрэн хангагдах юм.</p> <p>2. Бид анх оношлуур хийгдэж эхлээд худалдаалах боломжтой болсон талаар мэдээлэл аваад холбогдоход захиалга өгснөөс хойш доод тал нь 2 сарын хугацаанд нийлүүлэх боломжтой мөн оношлуурын олдцоос хамаарна гэсэн мэдээлэл өгсөн. 2000, 2000 ширхэгээр үечлээд захиалвал дээр болов уу гэж бодож байгаа.</p> <p>3. ЗГ болон ЭМЯ-с 15,000 ш оношлуур авах хүсэлт нь ГС-ийн санхүүжилтээр авахаар хүсэлт ирүүлсэн.</p>
---------	---

ДЭМБ	<p>Др.Сергей: Цаашид оношлуур авах асуудал нь 15,000 ширхэгээр тогтохгүй нэмэгдэхийг үгүйсгэхгүй. ДЭМБ-ийн төсөл дээр мөн 4 ш Gene Expert аппарат авах талаар тусгагдсан байгаа, хэрвээ уг аппарат шаардлагагүй гэж үзвэл энэ санхүүжилтийг оношлуур авах асуудал руу ч шилжүүлэх боломжтой тиймээс шаардлагатай байгаа тулгамдсан асуудлаа ярилцаад нэгдсэн байдлаар мэдээллээ солилцоод хамтран ажиллах боломжтой.</p>
------	---

ҮАБЗ	<p>Ж.Мөнхжаргал: Бид намар удаагийн хурлаар Жене эксперт аппаратны бусад шинжилгэ хийх боломж чадавхийн асуудлыг оруулж ирэх шийдвэр гаргаад үндсэндээ илтгэл мэдээлэл авч чадаагүй. Гэтэл одоо вирус оношилох асуудал орж ирж байна. Уг нь болно гэхдээ бид энэ аппаратыг тэр хэмжээнд ажиллуулах БИОаюулгүй ажиллагааны ямар түвшинд байгааг эмнэлгийн ажлын зах зухаас мэддэг улсууд мэднэ иймээс үнэлгээ хийхгүйгээр оношлуур худалдаж авах нь асуудалтай. Бид оношлуурын хараат байдалд орох эрсдэлтэй учир одоо ХӨСҮТ ашиглаж буй оношлуурыг үргэлжүүлэн авах эсхүл Монголчуудын өөрсдийн хийсэн оношлуур нь өнөөгийн нөөц боломжинд тулгуурлах тул тэрийг олноор үйлдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх талаар санхүүг чиглүүлэх нь цаашдын тасралгүй үйл ажиллагааг хангах юм. Бид олон хууль дүрэм чөлөөт өрсөлдөөн зах зээлийн үндсэн зарчмыг сөрөн байж нэг компаний нэрлэсэн оношлуур нийлүүлэх үйл ажиллагааг дэмжвэл үнэндээ Үндэсний Зохицуулах зөвлөл нэрнээсээ ичих хэрэгтэй болно. Хэрэв ЭМЯ нь биднээр шийдүүлэхгүй гэвэл өнөөдрийг хүртэл олон улс орнуудаас худалдаж болон хандиваар авсан аль оношлуур нь өнөөдр мэдрэг байгаа вэ гэдгээ мэдэж буй учир үргэлжлүүлэн авах нь зүйтэй.</p> <p>Төсөв чиглүүлэх 5 асуудал</p> <ol style="list-style-type: none"> 1. Бид арай өөр талаас нь манай улсын доголдоод байгаа оношлуур хүртлэх үйл ажиллагааны вирусын сорьц тээвэрлэхэд болон хамгийн чухал байдаг РНК-г ДНК болгон өөрчлөөд олшруулдаг уусмалыг эх орондоо үйлдвэрлэх үйл ажиллагаа 2. Биоаюулгүй ажиллагааны түвшинг ХӨСҮТ- өөс бусад газарт дээшлүүлэх үйл ажиллагаа 3. Нийт хүн амын дунд дархлал тогтоцыг судлах 4. Монгол гарч буй вирус хэлбэрийг судлах 5. Биоаюулгүй ажиллагааны үнэлгээг хийх зэрэгт санхүүжилтийг чиглүүлэх <p>Судалгааны төслийг ҮЗЗ-өөр хэлэлцүүлэх зэрэг санал өгч байна.</p>
------	--

Шийдвэр:

Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар			
Зөвшилцөл	x		
Санал хураалт	x	Санал хураалт (Тохирох нүдийг бөглөнө үү)	Гар өргөх x
		Нууц санал хураалт	
		Дэмжсэн>	10/12
		Эсрэг>	
		Санал өгөхөөс түдгэлзэх	

Хөтөлбөр #3	2018-2020 онд хэрэгжиж буй ХДХВ/ДОХ, Сүрьеэгийн төслүүдийн хэмнэгдсэн санхүүжилтийг дахин хуваарилах тухай
Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.	
Байхгүй	
Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тийм эсвэл үгүй)>	Үгүй

2018-2020 онд хэрэгжиж буй ХДХВ/ДОХ, Сүрьеэгийн төслүүдийн хэмнэгдсэн санхүүжилтийг дахин хуваарилах тухай

Ж.Лхамсүрэн-ХЗН-ийн мэргэжилтэн танилцуулгыг танилцууллаа. /Хавсралт №2/

Танилцуулгын товч хураангуй

Хэмнэлтийн зарцуулалтын тооцоо

№	Худалдан авах бараа, үндэслэл	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	2020 оны сүрьеэгийн нэмэлт санхүүжилтээр 12 ширхэг Жене Экспертийн аппарат авч байгаа. Эдгээр аппаратанд хэрэглэгдэх оношлуур анхнаасаа төсөвт тооцоологдоогүй учир 1 жилийн хэрэглээний оношлуураар хангах	12,672	11.5	145,437
2	Анх төсөл бичигдэж байхад сүрьеэгийн нийт ажилчдыг халдвараас хамгаалах зорилгоор хэрэглэх амны хаалтны тооцоог гаргахдаа нэг хүн 1 тусгай шүүлтүүртэй N95 амны хаалтыг 72 цаг зүүнэ гэж тооцоолж төлөвлөсөн. Гэхдээ 2019 онд Мэргэжлийн хяналтаас сүрьеэгийн нэгжүүдэд хяналт шалгалт хийж амны хаалтыг нэг удаа хэрэглэх зөвлөмж өгсөний дагуу дутагдалтай байгаа маскаар хангах	104,687	0.7	66,128
3	Сүрьеэгийн өвчлөл өндөртэй 9 аймгийн эмийн дасалтай сүрьеэгийн тасагт дутагдалтай байгаа амьсгалын аппаратыг ханган нийлүүлэх	9	15,382.0	138,435
Нийт үнэ				350,000

Хэлэлцсэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга

БСШУЯ	О. Янжмаа: ГС-ийн төслүүд нь ХДХВ/ Сүрьеэ өвчинтэй тэмцэхэд зориулагдсан байдаг тиймээс COVID-19 тэмцэх асуудлыг дэмжих замаар ХДХВ/ Сүрьеэ өвчнийг оношлох оношлуур аппарат, тоног төхөөрөмж авах зэрэг үндсэн чиглэлээсээ хазайлгүйгээр санхүүжилтээ зарцуулах боломж хэр байгаа талаар мэргэжлийн хүмүүс нь анхаараарай гэсэн санал хэлэх гэсэн юм.
АШУУИС	Л.Батгүвшин: 1. Заавал Gene Expert аппаратын оношлуур гэлтгүй өөр олон төрлийн илүү хурдан, хямд өртөгтэй оношлуурууд гарсан байгаа тиймээс тэр талаар мөн судлаарай. 2. SARS болон бусад дэлхий нийтийг хамарсан өвчинтэй холбоотой улс орнууд маш олон тооны эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлүүд хийсэн байдаг гэвч МУ-д тэр талаар ямар ч судалгаа, бүтээл байдаггүй. Тиймээс тодорхой хэмжээний төсвийг эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах хэрэгтэй гэж бодож байна.
Хариулт	Ж.Лхамсүрэн: ХДХВ/ Сүрьеэгийн төслөөс одоо хэмнэгдсэн санхүүжилт нь үндсэндээ COVID-19-д зориулсан дээр дурдсан тоног төхөөрөмж, оношлууранд зарцуулагдаж байгаа. Гэвч ГС-с дахин нэмэлтээр COVID-19-той холбоотой шинэ механизмийг бий болгосон ба тэндээс нэмэлт санхүүжилт авах боломжтой байгаа тэр санхүүжилтанд бид таны саналыг тусгах боломжтой юм.
ТББ	М.Сэргэлэн: Маскний тооцоог хэрхэн гаргасан бэ, анх эмч ажилтнуудыг хамгаалах маскыг 72 цаг зүүнэ гэж тооцож байсан, одоо тэгэхээр 2/3 нь дутагдалтай гэсэн үг үү. Нэмэлтээр авах маск нь хэд орчим эмч ажилтнуудад хүрэлцээтэй вэ?
Хариулт	Ж.Лхамсүрэн: Анх төсөл бичигдэж байхад Сүрьеэгийн нийт ажилчдыг халдвараас хамгаалах зорилгоор хэрэглэх амны хаалтны тооцоог гаргахдаа 1 хүн N95 маскыг 72 цаг зүүнэ гэж тооцож төлөвлөсөн. Гэхдээ 2019 онд Мэргэжлийн хяналтаас Сүрьеэгийн нэгжүүдэд хяналт шалгалт хийж маскыг 1 удаа хэрэглэх зөвлөмж өгсний дагуу дутагдалтай байгаа нийт 104,687 ш маскыг захиална.

ДЭМБ	Др.Сергей: ҮЗЗ гишүүдээс хүсэхэд бид COVID-19-тэй холбоотой яаралтай хариу арга хэмжээ авах хэрэгтэй байна. Үүнтэй тэмцэхийн тулд лабораторийн чадавхийг дээшлүүлэх тоног төхөөрөмж, оношлуур авах нь нэн чухал байна. ДЭМБ-с түргэвчилсэн оношлуурыг яг онош тавихад ашиглаж болохгүй гэж зөвлөж байгаа. Цаг алдахгүйн үүднээс Долгион та бүхэнд ДЭМБ-с гаргасан оношлууртай холбоотой гаргасан зөвлөмжийг одоо явуулах болно.
НҮБ	Б.Шинэтөгс: Санал хэлэх гэсэн юм. Тодорхой хэмжээний оношлуурыг энэ жилдээ багтаан авч ирэх боломжгүй бол зарим орон нутагт PCR тестийг авах боломжийг нэмэгдүүлвэл ямар вэ, PCR нь COVID-19 дараа ч гэсэн бусад өвчнийг илрүүлэх боломжтой юм.
ДЭМБ	Др.Сергей: PCR шинжилгээг зөвхөн УБ хот ХӨСҮТ дээр авдаг байсан бол одоо Дорнод, Дархан, Өмнөговь зэрэг хөдөө орон нутагт PCR шинжилгээг ашиглан COVID-19-г оношлох боломжтой болсон. Gene Expert-ийн хажуугаар бид PCR-г ашигласаар байх болно, тиймээс бид энэ чиглэлийн ханган нийлүүлтийг хангаж ажиллах болно.
ТББ	Г.Нямпүрэв: Өнөөдрийн хуралд ХЗН-с гадна ЭМЯ болон ХДХВ/ Сүрьеэгийн төслөөс холбогдох хүн нь ирж зарцуулагдах ёстой байсан санхүүжилт хэрхэн үлдсэн, юунд зарцуулах шаардлагатай байгаагаа үндэслэл тайлбараа сайн гаргаж танилцуулах хэрэгтэй байсан. Мөн ХДХВ/ Сүрьеэгийн төслийн салбар хүлээн авагч байгууллагууддаа анхаарч халдвар хамгааллын хэрэгсэлд нь зарцуулах шаардлагатай гэж бодож байна.
ШБ	Ж.Одгарьд: Өнгөрсөн Гүйцэтгэх хорооны хурал дээр яригдсан асуудал яригдаж байна гэж ойлгож байна. Мөн бусад гишүүдийн саналыг онлайнгаар авсан гэж ойлгож байна, зөв үү?
Хариулт	Б.Оюундарь: Ханшийн зөрүүнээс үүссэн 171,560\$ хэмнэгдсэн санхүүжилтийн зарцуулалтыг өнгөрсөн 83 дахь удаагийн цахим хурлаар санал авч 21 гишүүнээс 20 гишүүн дэмжсэн санал ирүүлж баталсан. Үүнийг ГС-нд явуулсан, ГС-с 171,560\$ дээр ЭМЯ-с ирүүлсэн 350,000\$ хэмнэгдсэн төсвөө нэмээд нэгтгээд аль болох эртхэн ирүүлэх хэрэгтэй гэсэн чиглэл өгсөн.
ТББ	Ж.Одгарьд: ҮЗЗ дарга, Дэд дарга, ЭМЯ төлөөлөл байхгүй байна, тиймээс бидний санал хүчинтэй юу?
Хариулт	Б.Оюундарь: Хүчинтэй. ҮЗЗ-д ЭМЯ-г төлөөлдөг 2 гишүүний санал дээр бусад Zoom-р оролцох боломжгүй гишүүдийн саналыг имэйлээр авна.
ХЗН	Ж.Лхамсүрэн: COVID-19-той холбоотой бүх агаарын тээвэр хаагдсан байгаа учир тээвэрлэлтийн асуудал маш удаашралтай байгаа. Бид дээрх оношлуур, тоног төхөөрөмжүүдээ ондоо багтааж хүлээж авахгүй бол эдгээр зардал нь ирэх оны төсвөөс хасагдах эрсдэлтэй. Иймээс хүсэлтээ аль болох эрт явуулж захиалгаа өгөх хэрэгтэй байна.Тиймээс та бүхэн шийдвэрээ яаралтай гаргаж өгнө үү.
ШБ	Ж.Одгарьд: ГС-аас COVID-19-той холбоотой шинээр гаргасан механизмаас нэмэлт санхүүжилт авах хүсэлтээ өгөх саналыг Ажлын хэсэгт гаргаж байна. COVID-19-д зориулах 171,560\$ болон 350,000\$ хэмнэгдсэн санхүүжилтын асуудал нь яаралтай бол одоо шийдэх саналтай байна. Харин үлдсэн 350,000\$ юунд зарцуулах вэ?
Хариулт	Ж.Лхамсүрэн: Үлдсэн 350,000\$-г бид өөрсдийн үндсэн үйл ажиллагаа болох Сүрьеэгийн дутагдалтай байгаа оношлуур болон эмнэлэгийн ажилчдын хамгаалах хэрэгсэл N95 маск, 9 аймагт сүрьеэгийн амьсгалын аппарат авахад зарцуулна.
ТББ	Г.Нямпүрэв: N95 маскыг ямар байгуулагуудад хэд орчимоор хангах вэ?
Хариулт	Ж.Лхамсүрэн: Сүрьеэтэй тэмцэх 3 ТББ байгууллагын 1 жилийн хэрэглээ нь 9000 ш, Монголын Сүрьеэтэй тэмцэх нийгэмлэг 5000 ш маск зарцуулах тооцоо ирүүлсэн.
ТБ	Ж.Мөнхжаргал: Жене эксперт гэдэг аппарат дээр хэрэглэгдэх оношлуур нь хэрэв Ковид-19 мутацад орвол ямар хэрэглэх боломжгүй хог худалдан авсан болно. Мөн хэдхэн сорьц уншина 5 хүрэхгүй гэсэн үг, яагаад Монгол улсад бодлого барьж буй яам нь ийм өчүүхэн байна вэ бид одоо ашиглаж буй Real Time PCR аа бүрэн хүчин чадлаар нь ашиглаад өнөөдрийг хүртэл худалдаж авсан оношлуурыг үргэлжлүүлэн авч болно. Бид яагаад нэг компаний оношлуурын хараат бүх хэрэглэгдэхгүй байх боломжтой оношлуурыг дэмжих ёстой вэ ЭМЯ хариулна уу. Энэ Жене экспертийн цөөн тоогоор хийгдэх оношилгоо нь цар тахлын үед ач холбогдолгүй учир асуудлыг эргэж судалж нягтална уу. Харин Real Time PCR-ын хүчин чадлыг нэмэгдүүлэх (200 300 түүнээс дээш шинжилгээг зэрэг унших) улсын хэмжээнд байгаа аппаратуудаа ажиллуулах био аюулгүй ажиллагаа бүхий бокс нээх асуудлыг дэмжих асуудлыг бүх гишүүдэд уриалж байна. Мөн энэ ҮЗЗ-д санал болгож буй аппарататанд хэрэглэх оношлуур нь хаалттай систем шаарддаг энэ асуудлыг яам дэмжин оруулж ирж буй нь арай ч дээ гэмээр байна бид яагаад ийм гадны гар хөл болсон улс орноо боддоггүй улсын асуудлыг хэлэлцэж цаг барьж суух ёстой вэ энэ асуудлыг зогсоох хэрэгтэй ҮЗЗ гишүүдээ уриалж байна.Монгол улсад хаалттай систем ашиггүй, чөлөөтэй системийн хэрэглээ үр дүнтэй юм. Бид үнэхээр тоног төхөөрөмж авах хэрэгтэй бол судалгаа хийж танилцуулах нь зүйтэй.

	Байгаа аппаратаа бүрэн хүчин чадлаар ашиглах бодлого барин ажиллаж чадаагүй байж дахин өөр оношлуур өөр аппарат 2-ын асуудалд санал өгөх нь цагаа олсонгүй.				
ТББ	Ч.Сэмжидмаа: Мөнхжаргалын ирүүлсэн саналтай би санал нийлэхгүй байна. Учир нь Gene Expert аппаратыг дан COVID-19-г оношлоод тогтохгүй сүрьег мөн оношлох боломжтой тиймээ бид дараа нь ашиглах боломжтой.				
ДЭМБ	Э.Долгион: PCR-н шинжилгээний лабораторийн нарийн орчин болоод мэргэшсэн эмч нар шаардлагатай байдгаас гадна өртөгийн хувьд өндөр үнэтэй байдаг. Харин сүүлд гарч ирсэн Gene Expert аппарат нь хурдан хугацаанд оношлох боломжтойгоос гадна өртөгийн хувьд харьцангуй боломжийн үнэтэй байгаа. COVID-19 холбоотой ДЭМБ-с оношлуур болоод тоног төхөөрөмжтэй холбоотой тус бүрт нь нарийн зөвлөмжүүдийг гаргасан болно.				
Зөвлөмж:					
Шийдвэр:					
Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар					
Зөвшилцөл	х				
Санал хураалт	х	Санал хураалт (Тохирох нүдийг бөглөнө үү)	Гар өргөх Нууц санал хураалт	х	
		Дэмжсэн>		9/10	
		Эсрэг>			
		Санал өгөхөөс түдгэлзэх			
Хөтөлбөр #4	Зохион байгуулалтын асуудал: <ul style="list-style-type: none"> • ҮЗЗ-ийн даргын хугацааг хэлэлцэх • Хяналтын хорооны зарим гишүүдийг чөлөөлж, нөхөн сонгох 				
Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.					
Байхгүй					
Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тийм эсвэл үгүй)>				Үгүй	
Хэлэлцсэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга					
ҮЗЗ-АА	Б. Оюундарь: 83 дахь удаагийн хуралаар ҮЗЗ-ийн дараагийн дарга болон Хяналтын хорооны зарим гишүүдийн өөрчлөлттэй холбоотой асуудлыг хэлэлцэх байсан боловч цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой хойшлогдсон тул энэ хурлаар хэлэлцэж байна. ҮЗЗ-ийн дүрмийн дагуу Хяналтын хороо нь 5 хүний бүрэлдэхүүнтэй, 5 өөр салбарын хүн байх ёстой. Хяналтын хорооны хурлаар ГС-ийн төслөөс үр шим авдаг салбар хүлээн авагч байгууллагт ажилладаг хүн Хяналтын хорооны гишүүн байх нь болзошгүй ашиг сонирхлын зөрчил үүсэж магадгүй гэж үзэн ҮЗЗ-ийн 3 гишүүнийг өөрчлөх санал гаргасан.				
	ҮНДЭСНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ХЯНАЛТЫН ХОРОО				
	№	Гишүүний нэр	Албан тушаал	ГС-гийн шаардлага	Хяналтын хорооноос оруулж буй санал
	1	<u>Ж.Мөнхжаргал</u>	<u>Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл, Хяналтын хорооны дарга</u>	<u>Хөтөлбөрийн менежмент</u>	<u>Төрийн байгууллага</u>
	2	<u>Ц.Даваасүрэн</u>	<u>Монголын Сүрьеэтэй Тэмцэх Нэгдсэн Холбоо</u>	<u>Өвчлөлийн талаарх туршлагатай</u>	<u>Анагаахын арьс өнгө, халдвартын кабинет</u>
	3		НҮБ-ын суурин зохицуулагчийн газар	Санхүүгийн менежмент	ЭМЯ Санхүү/Хүүлийн хэлтэс
	4	<u>Г.Нямпүрэв</u>	Залуус Эрүүл Мэнд ТББ	Олон нийтийн төлөөлөл	ХӨСҮТ
5	<u>С.Энхжин</u>	ЭМЯ-ны мэргэжилтэн	Ханган нийлүүлэлт	Хяналт шинжилгээ үнэлгээний алба	

ТББ	Г.Нямпүрэв: Тухайн үед ХХ-д ажиллаж байхдаа би Залуус Эрүүл Мэнд ТББ дээр National Grant дээр ажилладаг байсан, 8 сараас хойш миний тушаал солигдож Regional Grant руу орсон учраас ашиг сонирхлын зөрчил байхгүй болсон. Гэхдээ ХХ-д Олон нийтийн төлөөлөлийг зайлшгүй байлгах шаардлагатай.
ҮЗЗ-АА	Б. Оюундарь: Тухайн үед НҮБ-ийн суурин зохицуулагчийн газраас гишүүн ҮЗЗ-д орж ажиллах боломжгүй байсан бол одоо ҮЗЗ-д НҮБ-ын Хүн амын сангаас Шинэтөгс гишүүн шинээр орсон байгаа тиймээс ХХ-д ажиллах боломжтой гэж санал болгох гэсэн юм.
ХЭҮК	Ц.Адъяахишиг: Хяналтын Хорооноос Анагаахын арьс өнгө, халдвартын кабинет, ЭМЯ, ХӨСҮТ-с нийт 3 гишүүн оруулаа гэсэн санал гаргасан юм байна.
ТББ	Ч.Сэмжидмаа: ҮЗЗ-ийн ХХ нь гол нь хэрэгжиж буй төслүүд хэр үр дүнтэй зүйлд зарцуулагдаж байгаа талаар хянадаг гэж ойлгож байгаа тиймээс тухайн өвчлөлийн болоод салбарын талаар нарийн мэдлэгтэй хүн байх шаардлагатай.
ХЭҮК	Ц.Адъяахишиг: Хяналтын Хорооны бүрэлдэхүүнийг харахад ТБ болон ТББ-ын төлөөлөл байгаа боловч Олон нийтийн төлөөлөл байхгүй байна. Тиймээс Нямпүрэв байна уу, өөр хэн нэгэн төлөөлөл байх нь зүйтэй.
ШБ	Ж.Одгарьд: Олон нийтийн төлөөлөл байлгах саналыг дэмжиж байна.
ҮЗЗ-АА	Б. Оюундарь: 82 дахь удаагийн хурлаар ҮЗЗ-ийн даргын бүрэн эрхийн хугацааны талаарх асуудлыг авч хэлэлцэх үед дараагийн 3 жил хэрэгжүүлэх чухал цаг үе тохиосонтой холбоотой ГС-нд төслийг өргөн барих хүртэл Мягмар даргыг хугацааг сунгаж ажиллуулах саналыг ҮЗЗ-ийн гишүүд санал нэгтгэйгээр дэмжин баталсан. Бид 2020 оны 03 сарын 23-ний өдөр төслийг ГС-нд амжилттай илгээсэн. Иймээс дүрмийн дагуу дараагийн даргыг сонгох асуудлыг оруулж байна. ҮЗЗ-ийн дүрмийн дагуу ҮЗЗ-ийн дарга болон Дэд дарга нар өөр өөр салбарын төлөөлөл байх ёстой. Манай Дэд даргын хувьд төрийн байгууллагын төлөөлөл буюу ЭМЯ-ний Төрийн захиргааны удирдлагын газрын дарга байгаа, тиймээс шинэ дарга маань төрийн бус байгууллагын төлөөлөл байх ёстой.
ХЭҮК	Ц.Адъяахишиг: Өнөөдрийн хурлаар ҮЗЗ-ийн шинэ даргыг томилох асуудлыг хэлэлцэнэ гэж ойлгоогүй байсан. Харин ҮЗЗ-ийн даргын хугацааг хэлэлцэх гэж ойлгосон, хэрвээ бид хугацааны талаар хэлэлцэх бол дүрмэнд өөрчлөлт оруулах талаар шаардлагатай болно. Энэ ямар томъёоллоор орж ирсэн бэ?
ҮЗЗ-АА	Б. Оюундарь: 2020 оны 03 сарын 05-нд болсон ГХ-ны хурлаар ҮЗЗ-ийн дүрмэнд өөрчлөлт оруулаад дараагийн ҮЗЗ-ийн хурлаар гишүүдэд танилцуулах шийдвэр гарсан. Үүний дагуу ажлын хэсгийг 3 хүнтэй байгуулах явцад цаг үеийн чухал асуудал гарсан тул энэ асуудлыг хойшлуулсан байсан. Өнөөдөр энэ асуудлыг оруулж ирсэн нь Мөнхжаргал гишүүнээс ҮЗЗ-ийн нийт гишүүдэд захидал илгээсэн үүнийг бүх гишүүдэд илгээсэн. Үүн дээр ҮЗЗ-ийн дүрмийг өөрчлөх шаардлагагүй, батлагдсан дүрмийнхээ дагуу дараагийн даргаа сонгох ёстой гэсэн байсан тул хугацааг хэлэлцэх бус дараагийн ҮЗЗ-ийн даргыг томилох асуудлыг оруулж ирж байна.
ШБ	Ж.Одгарьд: Энэ асуудлыг хэлэлцэхэд ирц хүрж байна уу?
ҮЗЗ-АА	Б. Оюундарь: Одоо бол ирц хүрэхгүй байна.
ТББ	Г.Нямпүрэв: Бид ҮЗЗ-ийн даргыг сонгох асуудал дээр маш болгоомжтой хандах хэрэгтэй. Ирц хүрэхгүй дээрээс ҮЗЗ-ийн дарга, Дэд дарга, Хяналтын хорооны дарга нь ч байхгүй байхад энэ асуудлыг хэлэлцэх нь утгагүй юм.
ШБ	Ж.Одгарьд: Би Нямпүрэвтэй санал нэг байна. Энэ асуудлыг дараагийн хурал дээр энэ асуудалтай холбоотой гишүүд байх үед хэлэлцэх нь зүйтэй.
ХЭҮК	Ц.Адъяахишиг: Зохион байгуулалттай холбоотой чухал асуудлыг онлайнаар бус 5, 5-р өөр өөр зааланд эсвэл том зааланд хийх тал дээр Ажлын алба судална уу. Онлайнаар хурал хийх нь үр дүн багатай байгаад байна. ХЗН-с санал оруулахдаа ихэвчлэн цагийг нь тулгаж оруулж ирж шийдвэрлүүлдэг энэ тал дээр анхаарах шаардлагатай байна.
ҮЗЗ-АА	Б. Оюундарь: 2020 оны 04 сарын 29-нд болсон Гүйцэтгэх хорооны хурлаар 84 дэх удаагийн хурлыг Zoom-р хийх шийдвэр гарсаны дагуу Ажлын албанаас зохион байгуулж байгаа. Адъяахишиг гишүүний саналыг хүлээн авлаа.
ШБ	Ж.Одгарьд: Адъяахишиг гишүүнтэй санал нэг байна. ХЗН болон Ажлын албанд энэ талаар хэлдэг нь хэн хэнийхээ ажлыг хөнгөвчлөх, хурлыг аль болох үр дүнтэй болгох үүднээс хэлж байгаа юм. Гэхдээ COVID-19-тэй холбоотой бүх ажил удаашралтай, хүндрэлтэй байгааг ойлгож байгаа байх.
ТББ	Г.Нямпүрэв: Ажлын албанаас гишүүдтэй холбогдоод нэр дэвших хүсэлтэй хүмүүсийн нэрсийг гаргасан дээр байх гэж бодож байна.
ТББ	Т.Лэгээ: Нэр дэвших хугацааг ажлын 10 хоног, араас нь сонголтоо хийх ажлын 5 хоног, үүний дараа

	хурлаа хийх саналтай байна. COVID-той холбоотой дэлхий даяар бүх хурал цахимаар явагдаж байгаа энэ үед заавал дүрэм зөрчин царайгаа харалцаж хурал хийх шаардлагагүй гэж бодож байна.		
ТББ	Ч.Сэмжидмаа: 05 сарын 18-нд нэр дэвших хүмүүсийн нэрсийг гаргаад 05 сарын 22-нд ҮЗЗ-ийн 85 дахь хурлаа хийвэл гэсэн саналтай байна.		
Зөвлөмж:			
Шийдвэр:			
Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар			
Зөвшилцөл	х		
Санал хураалт	х	Санал хураалт (Тохирох нүдийг бөглөнө үү)	Гар өргөх Нууц санал хураалт
		Дэмжсэн>	7/8
		Эсрэг>	
		Санал өгөхөөс түдгэлзэх	

ШИЙДВЭР, АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Хөтөлбөр		ХАРИУЦАЖ БУЙ ХҮН	ХУГАЦАА
Хөтөлбөр #1	Өмнөх хурлын шийдвэрийн биелэлтийг танилцуулсан	ҮЗЗ Ажлын алба	
Хөтөлбөр #2	ГС-ийн дэмжлэгтэй ХДХВ/ДОХ-ын төслүүдийн хэмнэгдсэн санхүүжилтийг COVID-19 цар тахалтай тэмцэх чиглэлд дахин хуваарилах тухай саналыг Zoom онлайн хуралд оролцсон 12 гишүүнээс 10 гишүүн дэмжиж баталлаа. 2020 онд Сүрьеэгийн 2-р эгнээний эмийн худалдан авалтаас хэмнэгдсэн хэмнэлт: 350,000\$ 1. COVID-19-г оношлох оношлуур 14,730 ш-291,654\$ 2. Тээврийн зардал 20%-58,346\$	ХЗН, ҮЗЗ Ажлын алба	2020 оны 05 сарын 31
Хөтөлбөр #3	2018-2020 онд хэрэгжиж буй ХДХВ/ДОХ, Сүрьеэгийн төслүүдийн хэмнэгдсэн санхүүжилтийг дахин хуваарилах тухай саналыг Zoom онлайн хуралд оролцсон 10 гишүүнээс 9 гишүүн дэмжиж баталлаа. 2018-2019 оны гүйцэтгэлээс хэмнэгдсэн хэмнэлт: 350,000\$ 1. Сүрьег оношлох Gene Expert-н 1 жилийн хэрэглээний 12,672 ш оношлуур-145,437\$ 2. 104,687 ш N95 амны хаалт -66,128\$ 3. 9 аймагт сүрьеэгийн амьсгалын аппарат-138,435\$	ХЗН, ҮЗЗ Ажлын алба	2020 оны 12 сарын 31
Хөтөлбөр #4	Зохион байгуулалтын асуудал: *ҮЗЗ-ийн дараагийн даргыг сонгох асуудлыг ҮЗЗ-ийн дараагийн 85 дахь хурал дээр хэлэлцэхээр шийдвэрлэлээ. *Хяналтын хорооны зарим гишүүдийг чөлөөлж, нөхөн сонгох асуудал дээр гишүүний бүрэлдэхүүнд ХӨСҮТ-ийн төлөөлөлийн оронд Олон нийтийн төлөөллийг оруулах асуудлыг Zoom онлайн хуралд оролцсон 8 гишүүнээс 7 гишүүн дэмжиж баталлаа. *ҮЗЗ-ийн дараагийн 85 дахь удаагийн хурлыг 2020 оны 05 сарын 22-ний өдөр хийхээр товллоо. Хурлаар хэлэлцэх асуудлууд: 1. ҮЗЗ-ийн даргыг сонгох 2. COVID-19 цартахлаас үүдэн Глобаль сангийн дэмжлэгтэй ХДХВ/ДОХ, Сүрьеэгийн төслүүдэд үзүүлж буй нөлөө 3. Глобаль сангийн С19М механизмын талаар танилцуулах	ҮЗЗ-ийн гишүүд	ҮЗЗ-ийн дараагийн 85 дахь хурал (2020.05.22)

ДАРААГИЙН ХУРАЛ (ОГНОО, ХӨТӨЛБӨР)

Огноо	2020 оны 05 сарын 22
Хэлэлцэх асуудлууд	Хөтөлбөр

Хавсрах материал	Тохирох нүдийг бөглөнө үү	
	Тийм	Үгүй
Оролцогчдын бүртгэл	x	
Хөтөлбөр	x	
Бусад /илтгэлүүд/	x	
Хавсралт 1, 2	x	

БЭЛТГЭЛ АЖИЛ(Тохирох нүдийг бөглөнө үү			
	Тийм	Үгүй	
Хурлын тов, хөтөлбөрийг хурал болохоос 7 хоногийн өмнө хүргүүлсэн эсэх	x		14 болон 7 хоног
Бүртгэлийн хуудас	x		Хуралд оролцсон бүх хүмүүс
Хурлын тэмдэглэлийг хурал болсоноос 7 хоногийн дотор явуулах	x		7 хоног
Хүргүүлсэн тэмдэглэлд гишүүд саналаа өгөх, нэмэх, батлах	x		Цахим хаягаар
Хурлын тэмдэглэлийг гишүүд болон орлож ирсэн төлөөлөлд хүргүүлж байх	x		ҮЗЗ-ийн цахим хуудсанд 15 хоногийн дотор байршуулах

ТОВЧИЛСОН ҮГ:	
Товчлол	Утга
ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам
ҮАБЗ	Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл
ТБ	Төрийн Байгууллага
ҮЗЗ	Үндэсний Зорицуулах Зөвлөл
ТББ	Төрийн Бус Байгууллага
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
ХЭҮК	Хүний Эрхийн Үндэсний Комисс
ХЗН	Хөтөлбөр Зохицуулах Нэгж
ШБ	Шашны Байгууллага
ГХ	Гүйцэтгэх Хороо
ХХ	Хяналтын Хороо

БАТАЛСАН:			
Нэр>	Б.Мягмар	Огноо>	2020 оны 05 сарын 13
Албан тушаал>	ҮЗЗ-ийн дарга	Гарын үсэг>	
ХЯНАСАН:			
Нэр>	Б.Оюундарь	Огноо>	2020 оны 05 сарын 13
Албан тушаал>	ҮЗЗ-ийн зохицуулагч	Гарын үсэг>	
ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:			
Нэр>	Т.Батчимэг	Огноо>	2020 оны 05 сарын 13
Албан тушаал>	ҮЗЗ-ийн ажилтан	Гарын үсэг>	